

## ТӨСЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

“БиДиСЕК” ХК-тай 2009 оны 9 сарын 29-ны өдөр байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хүрээнд “ХайБиОйл” ХК-нд нийт 289’520’302 төгрөгний санхүүжилт хийгдэж (хүснэгт 5) компанийн шаардлагатай өр төлбөрийг барагдуулж, үйлдвэрлэлд нэн тэргүүнд шаардагдаж буй тоног төхөөрөмж болох VMAT I-36 шүүлтүүр, шүүлтүүрийн цэвэрлэгээний төхөөрөмж, тосны лабораторийн багаж, вакум насос зэргийг худалдан авч 2010 оны 5 сарын 14-нд Монголд авчиран бүрэн угсаргаанд оруулан үйлдвэрлэлийг хэвийн ажиллагаанд оруулаад байна.

Ингэснээр үйлдвэрлэлээс гарах бүтээгдэхүүний хэмжээ жигдэрч, борлуулалт хийх бүрэн боломжтой болоод байгаа ба гарсан бүтээгдэхүүнийг эхнээс нь Да Хүрээ техникийн зах, зам барилгын компаниудад борлуулж эхлээд байна.

Дээрх санхүүжилтийн цаана үлдэж буй санхүүжилтаар бид бүтээгдэхүүний чанарыг шинэ түвшинд гаргах өнгө сайжруулагч тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн цахилгаан эрчим хүчний нөөц хангамжийг бий болгох зорилгоор цахилгаан үүсгүүр, одоо худалдан аваад буй тоног төхөөрөмжийн үлдэгдэл 25 хувийн төлбөр зэргийг барагдуулах болно.

Бүтээгдэхүүний өнгийг сайжруулан зах зээлд гаргаснаар одоогийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, өндөр үнээр борлуулах боломж бүрдэх юм.